



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын ___ өдөр

Дугаар 11/589

Улаанбаатар хот

Монголын Хүүхдийн Урлан бүтээх төвийн
данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 2,247,500 /хоёр сая хоёр зуун дөчин долоон мянга таван зуун/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Монголын Хүүхдийн Урлан бүтээх төв /Д.Уранбилэг/-д зөвшөөрсүгэй.
2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Монголын Хүүхдийн Урлан бүтээх төв /Д.Уранбилэг/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГА  М.БАЯРАА



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны ~~1189~~ дугаар сарын ~~11~~ -ны өдрийн ~~1189~~ дугаар тушаалын хавсралт

Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Монголын Хүүхдийн Урлан бүтээх төв

/төгрөгөөр/

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага нэр	Эх үүсвэр
								Нэгжийн үнэ	Нийт үнэ		
1	Принтер	EPSON 3110	3 үйлдэлт	2020	Сайн	ш	1	417,900	417,900	Худалдаа хөгжлийн банк	Хандив
2	Принтер	Samsung M2020	өнгөт	2020	Сайн	ш	1	299,800	299,800		
3	Шарах шүүгээ	Dsewoo	хятад	2020	Сайн	ш	1	189,900	189,900		
4	Ус буцалгагч	Glanz	220 Bt	2020	Сайн	ш	1	89,900	89,900		
Тоног төхөөрөмжийн дүн								997,500.0			
1	Номын тавиур	хятад	модон	2020	Сайн	ш	1	1,250,000	1,250,000		
Тавилга, эд хогшлийн дүн								1,250,000.0			
Нийт бүртгэх хөрөнгийн дүн								2,247,500.0			